

ХЯТАД БА АСЕАН-Ы ОРНУУДЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БҮСИЙН ТУХАЙД

*Н.Отгонсүрэн**

Хятад, АСЕАН-ы орнуудын харилцаа урт удаан жилийн түүхтэй. АСЕАН нь 1967 оны 8-р сарын 8-нд байгуулагдсан бөгөөд гол зорилго нь Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг ахиулахад хамтран ажиллах явдал юм. Өнөөгийн байдлаар АСЕАН-ы гишүүн оронд Тайланд, Малайз, Сингапур, Филиппин, Индонез, Бруней, Вьетнам, Лаос, Камбучи, Бирм зэрэг 10 орон багтдаг бөгөөд нийт талбайн хэмжээ нь 4.5 сая км², хүн ам нь 530 сая ажээ. Урьдчилсан судалгаагаар 2010 онд АСЕАН-ы орнуудын үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ 955 сая долларт хүрэх юм.¹

Хятад, АСЕАН-ы хооронд 1991 оноос гадаад харилцаа сэргэж эхэлсэн. Улмаар 1996 онд Хятад, АСЕАН-ы орнууд нь яриа хэлэлцээр хийж, түнш орон болсон төдийгүй 1997 онд Хятадын удирдагч асан Зянь Зэмин болон АСЕАН-ы удирдагчид хамтран XXI зуун руу чиглэсэн сайн хөршийн харилцан итгэлтэй түншийн харилцаа тогтоохоо албан ёсоор шийдвэрлэжээ.

2001 оны 11-р сарын 6-нд Бруней нийслэлд АСЕАН болон Хятад, Япон, Солонгосын удирдагчдын ("10+3"), мөн Хятад, АСЕАН-ы удирдагчдын ("10+1") хурал болжээ. Уг хурлын үеэр Хятадын төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд асан Жу Рунжи 3 саналыг албан ёсоор дэвшүүлсэн. Үүнд: 1. Хятад, АСЕАН-ы орнуудын хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх, 2. Хятад-АСЕАН-ы чөлөөт худалдааны бүсийг 10 жилийн хугацаанд байгуулах, 3. Хоёр талын улс төрийн харилцан итгэлцэл, дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг болно. Хурлын үеэр хоёр талын удирдагчид болон мэргэжилтнүүд Хятад-АСЕАН-ы чөлөөт худалдааны бүсийг санал нэгтгэйгээр байгуулах болсон нь хоёр талын нягт хамтын ажиллагааг түргэсгэсэн, цаг үеэ олсон, стратегийн чухал бөгөөд зөв сонголт болсон юм. Тус чөлөөт худалдааны бүсийг байгуулах явцыг түргэтгэх зорилгоор АСЕАН-ы тал 2002 оны 2-р сард эдийн засгийн дээд хэмжээний уулзалтыг 2 удаа зохион байгуулжээ. Түүнчлэн 2002 оны 4-р сарын 1-нд Куьминд чөлөөт худалдааны бүсийн анхдугаар хурал, мөн тус оны 5-р сарын 14-16-нд Бээжинд Хятад-АСЕАН-ы зөвлөлийн анхдугаар хуралдаан тус тус болж, чөлөөт худалдааны

*Н.Отгонсүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

бүсийн зарчмын асуудал, цаашдын чиг хандлага, ажлын төлөвлөгөөний талаар нарийн тодорхой хэлэлцжээ.

Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийг байгуулахын ач холбогдол нь:

Нэгдүгээрт. Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийг байгуулснаар хоёр талын найрамдалт харилцаа хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, худалдааны цар хүрээг өргөтгөх, түүнчлэн тус бүс нутгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм. Сүүлийн жилүүдэд Хятад, АСЕАН-ы орнуудын худалдааны харилцаа маш эрчимтэй хөгжиж, хоёр тал байгалийн нөөц баялаг, аж үйлдвэрийн бүтэц, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг олон талаараа тус бүрдээ онцлогтой, харилцан бие биенээ нөхөх чадвартай зэрэг давуу талтай нь худалдааны цар хүрээг өргөтгөх өргөн боломж, нөөц бололцоог олгож байгаа юм. Тухайлбал Хятад, АСЕАН-ы эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар голлох байр суурийг эзэлдэг. Гэвч хоёр тал хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, техник технологийн шинэчлэл, механикжуулалтаараа харилцан адилгүй хөгжлийн үе шаттай. АСЕАН-ы хэд хэдэн орнууд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтаараа тэргүүний түвшинд байхад Хятад улс хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр харьцангуй өндөр хөгжсөн байх жишээтэй. Тус худалдааны бүсийг байгуулснаар Хятад улс экспортын зах зээлийн олон талт стратегийг хэрэгжүүлэх замаар экспортын гарцыг нэмэгдүүлж, валютын нөөцийг ихэсгэх, эдийн засгаа тогтвортой хамгаалж, эрүүл саруулаар хөгжүүлэх болно хэмээн хятадын мэргэжилтнүүд үзэж байгаа ажээ.

80-аад оны сүүл үеэс эхлэн Хятад, АСЕАН-ы орнуудын худалдааны жилийн дундаж өсөлт 20% байсан бол 1997 онд буюу Азийн санхүүгийн хямралын үед бага зэрэг буурч жилийн дундаж өсөлт 15% болсон байна. 2001 оны “9.11” –ны террорист халдлагын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг тийм ч таатай бус байсан хэдий ч Хятад, АСЕАН-ы орнууд худалдааны өсөлтөө хамгаалж улмаар экспорт, импортын нийт хэмжээ 41 тэрбум 615 сая долларт хүрч, өмнөх жилтэй харьцуулахад 5.3% өсчээ. Дээрх үзүүлэлтээс харахад Хятадын экспорт 18 тэрбум 385 сая доллар, импорт 23 тэрбум 229 сая доллар байсан нь 2000 онтой харьцуулахад 6 болон 4.7 хувиар өссөн байна. Өнөөгийн байдлаар АСЕАН-ы орнууд нь Хятадын гадаад худалдааны нийт өртгийн 8.3%-ийг эзэлдэг, Хятадын худалдааны 5 дахь том түнш юм. Харин Хятад улс нь АСЕАН-ы орнуудын гадаад худалдааны нийт өртгийн 3.9 %-ийг эзэлдэг, худалдааны 6 дахь том түнш болдог байна. ²

Хоёрдугаарт. Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийг байгуулснаар хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх төдийгүй Ази болон дэлхийн эдийн засгийн цаашдын тогтвортой хөгжилд идэвхитэй хувь нэмрээ оруулах нь дамжиггүй. Хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанаас үзэхэд 2001 оны эцсийн байдлаар АСЕАН-ы орнуудаас Хятадад нийт 17972 объектэд 53 тэрбум 468 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Хятадад ордог гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 7.2 %-ийг эзэлж байгаа бөгөөд үүнээс бодит хөрөнгө оруулалт нь 26 тэрбум 175 сая доллар байна. Харин Хятадаас АСЕАН-ы орнууд руу нийт 740 объектэд 1 тэрбум 91 сая долларын хөрөнгө оруулалтыг хийжээ.³

Хятад-АСЕАН-ы чөлөөт худалдааны бүсийг байгуулах явцад 2 тал хэд хэдэн төсөл дээр хамтран ажиллахаар болжээ. Юуны өмнө Хятад, Лаос, Бирм, Тайланд зэрэг 4 орон Меконг голын дээд урсгалын тээвэрлэлтийн орчны судалгааны ажлыг хамтран хийж, хятадын тал 5 сая доллар гаргахаар болжээ. Мөн Лаосын нутаг дэвсгэрт гуравны нэг нь хамаарагдах Куньмин-Банконгийн замыг байгуулах, Транс-Азийн төмөр замын шугам сонгох болон сэргээн засварлах, мөн ДОХ-оос урьдчилан сэргийлэх эмчилгээний төсөл зэрэг болно.

Хоёр талын мэргэжилтнүүдийн дүгнэж байгаагаар 10 жилийн хугацаанд тус чөлөөт худалдааны бүсийг байгуулснаар Хятад, АСЕАН-ы орнуудын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа улам өргөжихийн сацуу дараах хэд хэдэн тодорхой агуулга бүхий саналуудыг гаргасан байна. 1. Юуны өмнө худалдааны хөрөнгө оруулалтанд ашигтай, тус дөхөм болох арга хэмжээ авах, 2. АСЕАН-ы орнууд болоод цаашид АСЕАН-д шинээр нэгдэх орнуудад дэмжлэг тусламж үзүүлэх, 3. ДХБ-ын үндсэн зарчимд нийцүүлж, ДХБ-ын гишүүн бус АСЕАН-ы орнуудад онцгой боломж олгох, 4. Хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг банк санхүү, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, байгаль орчны хамгаалал, эрчим хүч, ойн аж ахуй зэрэг бүхий л салбарт өргөтгөх явдал юм.

Гуравдугаарт. Тус чөлөөт худалдааны бүсийг байгуулснаар Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн нягт хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэхэд үлгэр дуриалал болохоос гадна хоёр тал олон улсын тавцанд улс төрийн байр сууриа бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Хятад улсын хувьд дэлхийн эдийн засаг, худалдаа, улс төр, аюулгүй байдлын үйл ажиллагаанд оролцох эрх олгогдож байгаа төдийгүй Зүүн Азийн эдийн засгийн тогтвортой байдлыг

хангахад чухал дэмжлэг болох нь эргэлзээгүй. АСЕАН-ы орнууд нь Хятадын баруун өмнөд муж, бүс нутгийн экспортын гол зах зээл болох учраас энэ бүс нутгийн экспорт нэмэгдэх төдийгүй нэн ялангуяа Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх стратеги бодлогыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болох юм.

Дөрөвдүгээрт Хятад улс ДХБ-ийн гишүүн орон болсон нь Хятад, АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийг байгуулахад ашигтай нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Юуны өмнө Хятад улс дотоодын зах зээлээ өргөтгөх, хөгжингүй болон хөгжиж байгаа орнууд Хятадын зах зээл рүү чөлөөтэй орох нээлттэй боломж бүрдэж байгаа билээ. АСЕАН-ы орнуудын хувьд Хятадтай хөрш зэргэлдээ оршдог, 1.3 тэрбум хүн амтай маш том зах зээл рүү хөрөнгө оруулах нөхцөл бүрэн нээгдэж байгаа юм. Түүнчлэн өнөөгийн байдлаар 1978 оноос эхлэн 20 гаруй жил шинэчлэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлж эдийн засгийн салбарт ихээхэн амжилт олж байгаагийн сацуу улс төрийн салбарт ч багагүй шинэчлэлийг хийж байгаа Хятад улстай сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэх нь Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдалд ч ашигтай.

Хятад ДХБ-ын гишүүн орон болсноор дэлхийн зах зээлд эдийн засгийн өрсөлдөөн улам ширүүсч байна. Үүнд: Нэг. Экспортын зах зээлийн өрсөлдөөн. Хятад, АСЕАН-ы экспортын гол бүтээгдэхүүнд нэхмэл, сүлжмэл эдлэл, бэлэн хувцас, гэр ахуйн болоод бусад цахилгаан хэрэгсэл багтдаг бөгөөд экспорт нь голдуу Америк, Европын орнуудад төвлөрсөн нь зайлшгүй өрсөлдөөнийг бий болгож байна. Хоёр. Гадаадын хөрөнгө оруулалтын өрсөлдөөн. Гадаадын хөрөнгө оруулалт нь Хятад, АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хөгжилд гол нөлөө түлхэц өгдөг учраас тэд гадаадын хөрөнгийг татахыг чухалчилдаг. Гэвч олон улсын хөрөнгө мөнгөний хэмжээ хязгаарлагдмал учраас өрсөлдөөн ихтэй юм.

Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийг байгуулах үйл явц алхам алхамаар өргөжин тэлж байгаагийн зэрэгцээ зарим нэг бэрхшээл сөргөлдөөнтэй тулгарч байгаа ажээ. Үүнд Нэг. Чөлөөт худалдааны бүсийн механизмын асуудал. Харилцан адилгүй хөгжлийн түвшинтэй, өөр өөр системтэй гишүүн орнуудын ашгийн хувиарлалтын асуудлыг шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болоод байгаа ажээ. Хоёр. Удирдлагын эрхийн асуудал. Хятад улс нь АСЕАН-ы гишүүн орнуудын гол байр суурийг хамгаалахад мөн хөгжил буурай гишүүн орнуудад онцгой хөнгөлттэй татварыг хэрэгжүүлэхтэй санал нэгтэй байгаа. Гэвч чөлөөт худалдааны бүсийг байгуулах явцад удирдлагын эрхийн асуудал

хурцаар тавигдаж байна. Учир нь АСЕАН-ы гишүүн орнуудын эдийн засгийн хүчин чадлыг тус бүрд нь Хятадын эдийн засгийн чадавхитай харьцуулахад маш их зөрүүтэй. Гурав. Хятадын Өмнөд тэнгисийн эрхийн маргаантай асуудлыг шийдвэрлэх, хар тамхины наймаа, хууль бусаар шилжин суурьших, олон улсын террорист халдлага болон байгаль орчны бохирдлыг багасгах нь тулгамдсан асуудал болсоор байна.

Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийн хөгжлийн цаашдын хэтийн төлвөөс авч үзвэл 1 тэрбум 800 сая хэрэглэгчтэй, 14 сая 80 мянган км² газар нутагтай, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 2000 тэрбум доллар, худалдааны нийт дүн нь 1300 тэрбум доллартай тэнцэх хүчин чадал бүхий эдийн засгийн нэлээд том бүс болох ажээ. АСЕАН-ы орнуудын статистикийн урьдчилсан үзүүлэлтээр тус бүс нь дэлхийн хүн амын 30%-ийг, газар нутгийн 10%-ийг, валютын нөөцийн 40%-ийг тус тус эзэлдэг, хөгжиж байгаа орнуудыг нэгтгэсэн дэлхийн хамгийн том бүс болох хандлагатай байна.⁴

Мэргэжилтнүүдийн хийсэн судалгаагаар 2010 онд Хятад-АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийн дотоодын худалдааны нийт хэмжээ Европын Холбоо болон Хойд Америкийн чөлөөт худалдааны бүсийн түвшинд ойртох, түүнчлэн АСЕАН-ы орнууд руу хийх Хятадын экспортын нийт хэмжээ 10 тэрбум 600 сая доллар, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2 тэрбум 200 сая доллар, харин АСЕАН-ы орнуудаас Хятад руу хийх экспорт 13 тэрбум доллар болж тус тус өсөх урьдчилсан тооцоо гарчээ.⁵

Ашигласан материал

1. Te qu jing ji 2003.01.25 45-р тал
2. Zhong guo wai jiao 2003.01 59-р тал
3. Мөн тэнд 60-р тал
4. Japan Review 2003 22-р тал
5. <http://www.pku.edu.cn/>